



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/267

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Жаргалант сумын Хайрхан багт инженерийн хийцтэй ухаалаг худаг гаргах ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
	М.Цогт-Эрдэнэ	- Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн
	Д.Тогтохбаяр	- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Бямбажаргал	- Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн
	С.Баянмөнх	- Хайрхан багийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
	З.Уянга	- Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн мэргэжилтэн
	Б.Гантуяа	- Хайрхан багийн Засаг дарга

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын
мэргэжилтэн

С.Бандьхүү - "Алтайн хар сувд" ХХК-ны захирал

Нарийн бичгийн
дарга Г.Билгүүн - Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөх
багийн гишүүн

2. Инженерийн хийцтэй ухаалаг худгийн гүйцэтгэл, бичиг баримтыг шалган санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д нарт даалгасугай.

3. Тухай ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН